

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц...хууль зүйн...баталгааг бүрдүүлэх,...хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэслэл, журмыг тогтоосон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

2002 оноос хойших хугацаанд иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг үндэслэн олгосон гүйцэтгэх баримт бичиг дунджаар нийт гүйцэтгэх баримт бичгийн 70 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн бодит гүйцэтгэл оноос он дамжин 50 орчим хувьтай байсаар байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан зорилтын хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна. Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан “тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах”, “албадан ажил хийлгэх” зэрэг ялын хэрэгжилт хангалтгүй байгаа нь Эрүүгийн хуулийн 9.1-д заасан “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх” зарчмыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд иргэнд учирсан эд хөрөнгийн болон эдийн бус хохирлыг бүрэн нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нь гэмт этгээдийг олж илрүүлэн шийтгэхээс дутуугүй ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.1-т: “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.” гэж, 5.4.10-т: “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон телекамерын хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах, иргэний хэргийн талаархи

шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ.” гэж тус тус заасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Дээр дурдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан 2017 оны 7 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд ял, шийтгэлийн төрөл, хэлбэрийг шинээр тодорхойлж, хорих ялыг нээлттэй, хаалттай хорих байгууллагад, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад тус тус эдлүүлэх, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэл оногдуулахаар тусгаж, ял, шийтгэл, албадлагын арга хэмжээний төрлийг шинээр тодорхойлсон нь дээр дурдсан ял, шийтгэл оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих ажиллагааг шинээр журамлах шаардлагыг бий болгож байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Төслийн зорилго нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журам, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулах бөгөөд хуулийн төсөл нь 5 хэсэгтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр хэсэгт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ерөнхий үндэслэл, 2 дугаар хэсэгт: Иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа, 3 дугаар хэсэгт: Захиргааны болон зөрчлийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа, 4 дүгээр хэсэгт: Эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, 5 дугаар хэсэгт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлно.

I хэсэг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ерөнхий үндэслэл

Хуулийн зорилт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл, баримтлах зарчим, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тодорхойлолт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих нийтлэг шаардлага, хориглох үйлдэл, эс үйлдэхүйг тодорхойлно.

II хэсэг: Иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хоёрдугаар хэсэгт заасан зохицуулалтыг зарчмын хувьд хэвээр хадгалж, дараах зохицуулалтыг шинээр тусгана.

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал;
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх буюу шүүхийн шийдвэр гарснаас хойш хуульд заасан тодорхой хугацаа өнгөрсөн тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахгүй байх хугацааг тодорхойлох;

- Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг үүссэн шаардлага, нөхцөлөөс хамааран хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түдгэлзүүлэх, дуусгавар болгох;
- Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хэрэгжүүлдэг бүхий л арга хэмжээг /хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураан авах, эд зүйлд үзлэг хийх, нэгжлэг хийх, үнэлгээ тогтоох гэх мэт/ албадлагын арга хэмжээг тодорхойлж, тэдгээрийг гүйцэтгэх үндэслэл, журмыг тогтоох;
- Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг түдгэлзүүлэх, төлбөр төлөгч түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах тухай зохицуулалтыг шинээр авч үзэх;
- Шүүхээс олгосон гүйцэтгэх баримт бичигт төлбөр гаргуулах хөрөнгө, орлого, эрхийг тодорхой заадаг байх;
- Төлбөр төлөгчийн төлбөрт суутгахаар тогтсон хөрөнгийн төрөл, тэдгээрийн онцлогоос хамааран шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулах, үнэлгээ тогтоох онцлог, тэдгээрийг албадан худалдан борлуулах ажиллагааны журмыг нарийвчлан тогтоох;

III хэсэг: Захиргааны болон зөрчлийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

Захиргааны хэргийн талаархи шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч, эрх залгамжлагч заавал биелүүлэх үүргийг тодорхойлж, сайн дураар биелүүлээгүй тохиолдолд албадан биелүүлэх үндэслэл, журмыг тодорхой тусгана.

Зөрчлийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг, шийтгүүлсэн этгээд зөрчлийн хэргийн талаархи шийдвэрийг тогтоосон хугацаанд үл биелүүлсэн, эсхүл оргон зайлсан тохиолдолд шийтгэл оногдуулсан албан тушаалтан шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хандах, шүүх гүйцэтгэх баримт бичиг үйлдэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэх тухай зохицуулалтыг бий болгоно.

IV хэсэгт: Эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг биелүүлэх

2017 оны 7 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлтэй нийцүүлэн торгох, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах ял оногдуулсан болон Эрүүгийн хуульд заасан бусад албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тодорхойлж хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих ажиллагааны журмыг тусгана.

Эрүүгийн хуульд нийцүүлэн нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдлүүлэх харилцааг нарийвчлан тусгаж, нээлттэй, хаалттай хорих ангийн төрөл, зэрэглэл, ямар зэрэглэлд ял эдлүүлэх, зэрэглэл өөрчлөх үндэслэл, журмыг тодорхойлно.

V хэсэгт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог шинээр тодорхойлж, түүний алба хаагчийн баталгааг улс төрийн, хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн

болон бусад баталгаа болгон нарийвчлан зааж, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журмыг тодорхойлно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо, чиг үүрэг оновчтой болж, ял, албадлагын арга хэмжээг ялгамжтай, үр нөлөөтэй эдлүүлэх нөхцөл бүрдээ хорих ангийг нээлттэй, хаалттай хэлбэрт шилжүүлснээр хорих ялыг хувь хүний онцлогт тохируулан ялгамжтай эдлүүлэх нөхцөл бүрдэнэ.

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд хяналт тавих зориулалтаар эхний ээлжинд програм хангамж, компьютер, техник хэрэгсэл, электрон гавны иж бүрдэл худалдан авах болон хяналтын төв байгуулахад тодорхой хөрөнгө шаардагдана. Тогтоол гүйцэтгэгчийг тойргийн журмаар ажиллуулахад боловсон хүчний тоо нэмэгдэж, тэдгээрийн цалин хөлс, дүрэмт хувцас, нийгмийн баталгаатай холбоотой зардал шаардагдана.

Иргэний болон зөрчлийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийн биелэлтийг сайжруулж, иргэний зөрчигдсэн эрхийг сэргээх тогтолцоог бэхжүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаархи санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуультай уялдсан байна.

Хуулийн төслийг Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

-----ooOoo-----